

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр, Мягмар гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-21
1. “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	7-8
2. Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	8-12
3. Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	12-18
4. Дулааны цахилгаан станцуудын хаягдал үнстэй холбоотой асуудлаарх мэдээлэл сонсох	18-21

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
11 дүгээр сарын 25-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 42 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: П.Батчимэг, Х.Булгантуяа;

Томилолттой: Г.Очирбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Тулга;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Ж.Бат-Эрдэнэ, О.Батнайрамдал, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар, Б.Жавхлан, О.Цогтгэрэл.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хэлэлцэх асуудлын 2 дугаарт байгаа “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн ажлын хэсэг ажиллаж, зарчмын зөрүүтэй саналын томьёолол бэлтгэхэд хугацаа шаардлагатай байгаа тул хэлэлцэх асуудлын дарааллаас хойшлуулах тухай үг хэлж, Байнгын хорооны дарга Р.Сэддорж уг асуудлыг хойшлуулав./16:46/

Нэг. “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Р.Сэддорж: “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг, Да.Цогтбаатар нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Р.Сэддорж хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэгт заасны дагуу Байнгын хорооны дарга Р.Сэддоржийг нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар сонгох санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан горимын саналын дагуу нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Байнгын хорооны дарга Р.Сэддоржийг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 9
Бүгд: 17
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэг нь 2024 онд хүчингүй болсон тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүд Д.Үүрийнтуяаг сонгох санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан горимын саналын дагуу нэр дэвшигчийн сонсголын даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяаг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Р.Сэддорж: “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 4

Бүгд: 19
78.9 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, мөн яамны Гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Т.Ганбаатар, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Ашигт малтмал газрын тосны газрын Газрын тос, бүтээгдэхүүний газрын дарга Ч.Чулуунбат, мөн газрын Газрын тос, бүтээгдэхүүний хэлтсийн дарга Д.Даваабаяр, Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын ахлах эдийн засагч О.Одгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, Л.Соронзонболд, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын ахлах эдийн засагч О.Одгэрэл нар хариулж, тайлбар хийв.

Р.Сэддорж: Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 7
Бүгд: 20
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Дулааны цахилгаан станцуудын хаягдал үнстэй холбоотой асуудлаарх мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрчим хүчний яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга И.Лувсанцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Б.Пунцагбалжир, “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Мөнхөө,

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Минжинхүү, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Амартүвшин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Дулааны цахилгаан станцуудын хаягдал үнстэй холбоотой асуудлаарх мэдээллийг Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн Эдийн засгийн байнгын хорооны дараагийн хуралдаанаар дээрх мэдээлэл сонссонтой холбогдуулан Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцүүлэх горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан горимын саналаар мэдээлэл сонссонтой холбогдуулан Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 6
Бүгд: 20
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүд Дулааны цахилгаан станцуудын хаягдал үнстэй холбоотой асуудлаарх мэдээллийг сонслоо.

Уг асуудлыг 17 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 15 минут үргэлжилж, 32 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 17 цаг 57 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
16 цаг 47 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Монгол Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анар, Цэндийн Баатархүү, Ренчиндоржийн Батболд, Нацагдоржийн Батсүмбэрэл, Пүрэвжавын Ганзориг, Батжаргалын Заяабал, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Мэндбаярын Мандхай, Бадрахын Найдалаа, Эрдэнэбилэгийн Одбаяр, Бадамдоржийн Пунсалмаа, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ренчинбямбын Сэддорж, Агваанлуvsангийн Ундраа, Болдын Уянга, Саруулсайханы Цэнгүүн, Доржсүрэнгийн Үүрийнтуяа нарын гишүүд оролцож байна. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцууллаа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 53,1 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал.

1.“Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

2.“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Засгийн газраас 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

3.Дулааны цахилгаан станцуудын хаягдал үнстэй холбоотой асуудлаар мэдээлэл сонсох гэсэн 3 асуудал хэлэлцэхээр энэ 7 хоногийн тов дарааллыг Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөс баталсан боловч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлын дарга санал ирүүлсэн тул зөвлөл дахин хуралдаж, “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хороогоор хэлэлцүүлэхээр тов дарааллыг шинэчлэн баталсан.

Мөн Байнгын хорооны хурлын хэлэлцэх асуудалд Стратегийн ач холбогдол бүхий бүрэлдэхүүнийг хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх гэсэн ийм 5 асуудлыг өнөөдөр хэлэлцэнэ. Ингээд хэлэлцэх асуудалд өөр саналтай гишүүд байна уу. Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Улсын Их Хурлын даргын захирамжаар “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” ажлын хэсгийг байгуулсан. Өнгөрсөн 7 хоногийн 3 дахь өдөр Их Хурлын даргын захирамж гараад, ингээд өнгөрсөн 5 хоногийн хугацаанд бол манай ажлын хэсэг маань 20 орчим хүний

бүрэлдэхүүнтэйгээр ажиллаад явж байгаа. Тэгээд би бас Байнгын хорооны гишүүдээс, даргаас чиглэл авч, хүсэлт гаргах гэсэн зүйл нь өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх байсан, ажлын хэсгээс бэлтгэж оруулах байсан санал, дүгнэлтийн төсөл болон анхны хэлэлцүүлгийг хойшлуулж өгөх саналыг гаргаж байгаа юм. Тэгээд ажлын хэсэг одоогийн байдлаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо бэлдээд, өнөө оройдоо дуусгаад, дараагийн Байнгын хорооны хурлаар оруулахад бэлэн болохоор ийм төлөвлөгөөтэй байна. Тэгэхээр болж өгвөл энэ 7 хоногийн 4 дэх өдрийн өглөөгүүр Байнгын хорооны хурлыг зарлан хуралдуулж, үндсэн чиглэл батлах энэ асуудлыг хэлэлцэж өгөөч гэсэн хүсэлтийг тавьж байгаа. Тэгээд цаг хугацааны хувьд үндсэндээ 5-хан хоногийн хугацаанд том бодлогын баримт бичиг дээр ажлын хэсэг ажиллаж байгаа учраас нэлээн ажиллагаа бас орж байна. Нэлээн зарчмын зөрүүтэй саналууд бас ажлын хэсгийн гишүүдээс гарч байна. Тэгээд энэ болгон дээр манай дэд ажлын хэсгийнхэн маань ажиллаад, цаг хугацаа нэлээн зарцуулагдаж байна гэдгийг харгалзаж үзээч гэж хүсэж байна.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн даргын саналаар ажлын хэсэг саналын томъёоллоо нэгтгэж дуусаагүй байгаа учраас хэлэлцэх асуудлын 2-т байгаа “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлыг хойшлууллаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 16 дугаар тогтоолоор байгуулсан бөгөөд тус ажлын хэсэгт Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг орж ажиллах хүсэлтээ Байнгын хороонд ирүүлсэн. Уг хүсэлтийг үндэслэн “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг бэлтгэсэн байна. Уянгахишиг гишүүнээс ирсэн бичиг энэ байна.

Байнгын хорооны тогтоол.

“Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолоор байгуулагдсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт Улсын Их Хурлын гишүүн Уянгахишигийг өөрийн хүсэлтийг нь үндэслэн нэмсүгэй.

Байнгын хорооны дарга.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Санал хураалт явуулж эхэлье. Гишүүдийн ирцийг хүлээе. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалтын томъёоллыг танилцуулъя.

“Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоол батлагдлаа. “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

16.51 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал 2.

Дулааны цахилгаан станцуудын хаягдал үндэстэй холбоотой асуудлаарх мэдээллийг хэлэлцэж эхэлье. Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн байхгүй байгаа учраас дараагийн асуудалдаа орж байя.

Хэлэлцэх асуудал 3.

“Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол

“Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох тухай, сонсгол даргал даргалагчийг сонгох тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монголбанкны Ерөнхийлөгчид нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.Нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяаг томилсугай.

3.Нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл хүлээн авахаар тогтоосугай.

4.Нэр дэвшигчийн сонсголын зарыг нийтэд мэдээлэх, сонсголын бэлтгэл ажлыг холбогдох хууль, дүрэм, журамд заасны дагуу зохион байгуулахыг Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай.

Эдийн засгийн байнгын хорооны дарга.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Ганзориг гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Ганзориг.

П.Ганзориг: Энэ Монголбанкны Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн энэ сонсголтой холбоотой ер нь энэ томоохон томилгоонууд ялангуяа энэ Их Хурлаас томилдог субъектүүд, дарга нар байж байна. Үндэсний Аудитын газрын даргаас авхуулаад Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Зохицуулах хорооны дарга гээд энэ Монгол Улсын эдийн засаг, цаашдын энэ салбаруудын хөгжлийн бодлогод чухал нөлөөтэй хүмүүсийг бас томилох сонсголыг зохион байгуулахдаа эрх барьж байгаа намаас төлөөлж гишүүдээр уг нь даргалуулмааргүй байгаад байгаа юм. Ер нь саяын жил гаруй ингээд сонсгол явж байхад эрх барьж байгаа нам хүмүүсээ оруулж ирдэг. Тэгээд сонсгол нь бас нөгөө хүмүүсээ ивээд, чиглүүлээд, чирээд явдаг. Тэгээд тэр салбарыг чинь хувь заяаг шийдэх гэж байгаа хүмүүс учраас бас тэр дээр тодорхой хэмжээнд өөр сөрөг хүчний байдаг юм уу эсвэл намын гишүүдээс даргалуулаад, иргэдэд бас маш сайн мэдээлэл өгөөд, асуулт асуугаад ингээд явах боломжийг нь уг нь хангавал зүгээр гэсэн ийм саналтай байгаа юм. Баярлалаа.

Р.Сэддорж: Сонсголын хувьд бол Монголбанкны Ерөнхийлөгчийн хугацаа 11 сарын 23-нд дууссан. Өмнөх Ерөнхийлөгчийн хугацаа Улсын Их Хурлын дарга хуулийн дагуу саналаа ингээд оруулж ирж байна. Сонсгол даргалагчийн хувьд бол яах вэ өнгөрсөн 1 сард болсон 24 хүний сонсголыг бол миний бие удирдаад явж байсан. 13 цаг сонсголыг зохион байгуулж байсан. Тасралтгүй зохион байгуулж байсан. Тэгэхээр бол аль нэг нам гэхээсээ бүгдээрээ бас саналаа нэгтгээд л ингээд явчихъя гэсэн ийм саналтай байна. Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар.

Да.Цогтбаатар: Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Сэдээ дарга аа, таны гараар могой бариулах гэж байхад та тэрийг нь дуртай нь аргагүй барья даа гээд. Сая энэ Ганзориг гишүүн ч гэсэн хэлээд байна. Энэ Улсын Их Хурлын тогтоол байгаа. 2021 оны 7 сарын 2-ны өдрийн 58 дугаар тогтоол. Нийтийн албан тушаалтныг томилох Улсын Их Хурлын тухай Дэгийн хуулийг зохицуулж байгаад энэ тогтоолыг удирдлага болгож барьж ажиллана шүү гээд 58 дугаар тогтоол баталчихсан байхгүй юу. Энэ тогтоол дээр сонгон шалгаруулалтыг зөвхөн Эдийн засгийн байнгын хорооны дарга буюу Байнгын хорооны дарга нь өөрөө сонсголыг даргална л гэж байгаа юм. Тэрнээс аль нэгэн нам олонх болсон намдаа танайх өөрийнхөө мэргэжлийн бус хүмүүсийг томилчих гээд сонсголын асуудлыг эрх баригч намд бэлэглэдэггүй. Та энийг энэ чигээр нь явуулчих юм бол магадгүй Сэддорж дарга Эдийн засгийн байнгын хорооны дарга гэдэг албан тушаалаараа Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр огцорч магадгүй. Яг энэ асуудал өмнө нь яваад Цэц дээр шийдэгдсэн асуудал. Тэгэхээр таныг мэдэхгүйгээр чинь далимдуулаад таны гараар Монгол Ардын нам могой бариулах гээд байна гэдгийг 1 дүгээрт анхаарах хэрэгтэй.

2 дугаарт бурхан олдохгүй бол буцахдаа зална гэж. Яах вэ энэ Ерөнхий сайдын бүрэн эрхийг ойлгож байна. Улсын Их Хурлын гишүүдээсээ ёстой мэргэжлийн бус хамаагүй сайд нарыг томилж байна. Одоо дүүрч. Хамаа алга. Гэтэл Монголд банк санхүүгийн салбарт ажиллаж байгаа мянга мянган залуучууд байхад хаа байсан бараг л физикч гэх нь холгүй нэг нөхрийг авчраад Монголбанкыг улс төрөөс бүр хараат бусаар, Засгийн газраас хараат бусаар, Улсын Их Хурлаас хараат бусаар ажиллаж байж инфляцыг тогтоон барина. Мөнгөний бодлогыг тогтоон барина гэдэг

ийм мэргэжлийн ажлыг хийх хүнийг хаа байсан Сангийн яаман дээр ажиллаж байсан, Тавантолгойн БЭТ-ээр ажиллаж байсан, Эрдэнэс Монгол дээр гийгүүлсэн юм байхгүй, Хөгжлийн банкны ТУЗ-ийн шийдвэр гаргасан бүх хүмүүс хуулийн хаалга татаж байхад энэ нөхөр ганцаараа сугараад л үлдсэн. Одоо болохоор яаж байна гэхээр гишүүдийн өрөөгөөр дамжаад л намайг дэмжээд өгөөч гээд гүйгээд яваад байх юм. Ийм ичдэггүй ийм нэг улаан даргын төлөө төрчихсөн ийм хүмүүсээ больж болдоггүй юм уу. Монгол Ардын нам. Учрал дарга бол уг нь ёстой шинэ залуу ороод ирлээ, гоё удирдах юм бодсон чинь анхных нь энэ санал нь үнэхээр ой гутмаар санал орж ирж байгаа юм. Энийгээ бараг нэр дэвшигчийг эгүүлэн татаж байгаад, сонсголыг хуулийн хүрээнд явуулахыг Эдийн засгийн байнгын хорооны даргаас шаардаж байна.

Энэ нэр дэвшигчээ буцааж татаж, мэргэжлийн хүнийг оруулж ирэхийг бас Их Хурлын дарга Учралаас шаардаж байна.

Р.Сэддорж: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Тайлбарлая. Төв банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монголбанкны Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлын даргын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурлын хурал нэр дэвшигчийн сонсгол хийж, 6 жилийн хугацаагаар томилно.” гэсэн хууль заалт байгаа. Тэгээд нэр дэвшигчийг оруулж ирж байгаа нь бол энэ чинь хуулиараа явж байна. Тийм ээ. Хуралдаан даргалагчийг хэнээр даргалуулах вэ гэдэг дээр бол өөр саналтай гишүүд байна уу. Лодойсамбуу гишүүн санал байхгүй юу. Тэр нь яах вэ, тэр дараагийн асуудал байна.

Одоо санал хураалт явуулъя. Үүрийнтуяа гишүүн чинь манай Байнгын хорооны гишүүн л дээ. Эдийн засгийн байнгын хорооны гишүүдээс даргална гэсэн л заалт байгаа. Санал хураах уу. Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд ирцдээ орсон уу. Эхлээд хуралдаан даргалагчийг Үүрийнтуяа гишүүнээр даргалуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Сонсголыг Байнгын хорооны дарга даргалъя. Тогтоолыг дахиж уншъя. Тогтоолыг дахиж уншъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.

“Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол банкны Ерөнхийлөгчид нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.Нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн миний бие /Сэддорж/-ийг томилсугай.

3.Нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг Улс 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл хүлээн авахаар тогтоосугай.

4.Нэр дэвшигчийн сонсголыг зарыг нийтэд мэдээлэх, сонсголын бэлтгэл хангах ажлыг холбогдох хууль дүрэмд заасны дагуу зохион байгуулахыг Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай. Байнгын хорооны дарга гэсэн байна.

Сая хууль уншлаа. Холбогдох Байнгын хорооны дарга даргална гэсэн байна. Ингээд сүүлийн уншсан төсөлтэй холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу. Алга байна. Санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтад бэлдье. Саналын томьёоллыг уншъя.

“Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох тухай, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 47,1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Мандхай гишүүн горимын санал гаргая.

М.Мандхай: Нийтийн сонсголын тухай хуулийн 18.7 дахь хэсэг дээр гарсан энэ тогтоол өөрөө 2024 оны 5 сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон. Тэгэхээр энэ тогтоол бол угаасаа хүчингүй байгаа учраас хууль зөрчсөн юм байхгүй. Тэгээд хурлыг Монгол Ардын намын бүлгээс гаргаж байгаа шийдвэрийн дагуу Үүрийнтуяа гишүүнийг энэ сонсголыг ахлуулахаар санал болгож байна. Тэгээд энэ дээр санал хурааж өгөөч ээ. Үүрийнтуяа.

Р.Сэддорж: Мандхай гишүүнийн горимын санал гаргая.

М.Мандхай: Саяын саналыг хүчингүй болгож өгнө үү. Байнгын хорооны дарга аа, саяын 18.7-той холбоотой санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү. Сая энэ Нийтийн сонсголын тухай хуулийн 18.7 өөрөө 2024 оны 5 сарын 16-ны өдөр хуулиар өөрчлөөд, хүчингүй болгосон байгаа. Тэгэхээр саяын санал хураалт бол өөрөө хүчингүй тогтоол дээр үндэслэсэн санал хураалт байгаа учир энэ саяын санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү.

Р.Сэддорж: Мандхай гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Одоо хүчингүй болгох санал хураалт. Ингээд Мандхай гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгохыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 76,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Заяабал горимын санал гаргана. Хэвээрээ

Б.Заяабал: Би нэг горимын санал гаргах гэсэн юм. Монголбанкны Ерөнхийлөгчийг томилохтой холбоотой сонсгол зохион байгуулах, сонсгол даргалахтай холбоотой асуудлыг бид нар яриад байгаа. Тэгээд энэ дээр бол Тухайн Байнгын хорооны гишүүн хэн нь ч сонсгол даргалж болдог. Би бас өмнө нь Санхүүгийн зохицуулах хорооны гишүүдийг бас сонгох сонсголыг бас даргалж байсан. Байнгын хорооны даргын саналаар Байнгын хороо дээр санал хураалгаад, би сонсголыг бас даргалж байсан түүхтэй. Тэр үед бас хууль дүрэмд нийцээд л явж байсан гэж үзэж байгаа. Тэгээд энэ удаагийн сонсголыг Байнгын хорооны дарга Сэддорж даргын оруулж ирсэн саналын дагуу Үүрийнтуяагаар даргалуулъя гэдэг горимын санал гаргаж, санал хураахыг хүсэж байна.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Заяабалын гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Одоо санал хураалт. 57,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл түрүүн уншигдсан. Санал хураалт явуулж дууслаа.

“Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох тухай, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя. Саналын томъёолол.

“Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох тухай, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. 78,9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

“Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

17.21 цаг.

Дараагийн хэлэлцэх асуудал нэн яаралтай горимоор чуулган дээр дэмжигдсэн.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Гонгорын Дамдинням танилцуулна. Сайдын микрофоныг нээе.

Г.Дамдинням: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.9-д “Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэх шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна.” гэж заасан.

Манай улсын газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-ын Засгийн газар болон нийлүүлэгч компаниудаас тус улсын дотоодын зах зээлийн нөхцөл байдал, эрэлт нийлүүлэлттэй холбоотойгоор гаргасан экспортын хязгаарлалт, үйлдвэрлэлийн процесс, ээлжит засвар, төлөвлөгөөт ажлаас шалтгаалсан нийлүүлэлтийн хэмжээний бууруулалт зэрэг арга хэмжээнүүд нь манай улсын шатахууны хангамжийн тогтвортой байдалд шууд нөлөөлж, тасалдал, хомсдол үүсгэн эрэлтийг нэмэгдүүлж үнийн хэлбэлзлийг бий болгосоор ирсэн.

Улс орны нийгэм, эдийн засаг, уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлттэй холбоотойгоор манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ жил бүр өсөн нэмэгдэж байгаа бөгөөд 2023 онд 2,4 сая тонн, 2024 онд 2,8 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн тус тус импортлон хэрэглэж, өмнөх оны мөн үеэс даруй 21 хувиар өссөн бол 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар импортын хэмжээ 2,3 сая тоннд хүрээд байна. Ард иргэдийн өргөн хэрэглээний АИ-92 авто бензиний хэрэглээ 2024 онд сард дунджаар 60 мянган тонн байсан бол 2025 онд сард дунджаар 80 мянган тонн хүрч өсөөд байгаа боловч ОХУ-ын Роснефть компанитай хийсэн гэрээний хүрээнд хөнгөлөлттэй үнээр буюу 705 ам.доллараар 1 тонн тутмыг тогтмол үнээр нийлүүлж буй энгийн АИ-92 авто бензиний сард нийлүүлэх хэмжээ тодорхой шалтгааны улмаас 60 мянган тонноор хязгаарлагдаж, нэмэгдүүлэх боломжгүй нөхцөл байдалтай байна.

Мөн уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлтийг дагаад дизель түлшний хэрэглээ сард 140 мянган тоннд хүрч байгаа тул хэрэглээнд дутагдаж буй 20 мянга орчим тонн АИ-92 авто бензин, 25 мянга орчим тонн дизель түлшний хэрэглээг бусад эх үүсвэр буюу БНХАУ-аас худалдан авч хангах нөхцөл байдал үүсээд байна. Шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хангах, улсын хэмжээнд багадаа 30-аас доошгүй хоногийн тогтмол нөөцтэй байх, нөөцийг бүрдүүлэх, хадгалах савны хүчин чадал, багтаамжийг нэмэгдүүлэх хүрээнд импортлогч, борлуулагч аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийг бууруулах, шуурхай шийдвэр гаргах эрх зүйн зохицуулалттай болох шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Иймд олон улсын худалдааны нөхцөл байдал, гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан дотоодын зах зээл дээр стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн болох шатахууны хангамж, нийлүүлэлтэд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, тасалдал, хомсдолоос урьдчилан сэргийлэх, даван туулах арга хэмжээг тодорхойлох, нөөцийг бүрдүүлэх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулан танилцуулж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Очболдын Одгэрэл Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын ахлах эдийн засагч, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Туулхангай Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Чулуундагвын Чулуунбат Газрын тос бүтээгдэхүүний газрын дарга, Даваахүүгийн Даваабаяр Газрын тос бүтээгдэхүүний газрын хэлтсийн дарга.

Хуулийн төслийн талаар хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Алга байна. Батсүмбэрэл гишүүнийг нэмье. Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл.

Н.Батсүмбэрэл: Хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Тэгээд энэ хууль 5 жилийн хугацаатай хэрэгжих хууль юм байна. Тэгээд энэ 5 жилийн хугацаандаа стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн маань хэвийн болчихно гэж үзэж байна уу. Энэ хооронд ямар арга хэмжээ та бүхэн авах гэж байна. Сая үүссэн бензиний хомсдолын асуудлууд ер нь шалтгаан юу байсан бэ. Үүнийг дахиж гарахгүй байх тал дээр яам, холбогдох байгууллагууд ямар арга хэмжээ авч ажиллаж байна вэ гэдгийг асууя.

Р.Сэддорж: Хариулт 5 номер.

Г.Дамдинням: Батсүмбэрэл гишүүний асуултад ариулъя. 5 жилийн хугацааг яагаад тавьж байгаа вэ гэвэл манай улсын нийт импортын шатахуун, шатах, тослох материалын нийт импортын 95-97 хувийг манай хойд хөрш маань нийлүүлдэг. Хойд хөршийн маань үйлдвэрүүдэд шинэчлэх, мөн бас геополитикийн нөхцөл байдалтай холбоотой зарим ажиллагааны хүрээнд бас саатлууд үүсээд байгаа. Тэгэхээр энэ

олон улсын судлаач, шинжээчдийн үзэж байгаа байр суурийг харвал энэ нөхцөл байдал бол ойрын ирээдүйд бас бүрэн шийдэгдэх нь эргэлзээтэй байгаа учраас хуулийн төслийг 5 жилийн хугацаа хүртэл тавья гэсэн ийм хугацаатай орж ирж байгаа.

2 дугаар асуудлын тухайд бол саяын хямралт байдлын асуудал бол импортоор орж ирсэн манай улсын хэрэглээний импортын тоон мэдээг сараар нь харвал ОХУ болон БНХАУ-аас яг нийлүүлдэг хэмжээндээ л нийлүүлсэн байгаа. Тэгэхээр энэ бол ард иргэдийн дунд бас нээлттэй мэдээллийн эх үүсвэрээс янз бүрийн буруу, зөв мэдээллээс үүдэж бас очер үүссэн, дугаарлалт үүссэн гэдэг ийм байр суурьтай байна. Бид 58 мянгыг 10 дугаар сард авах байсан бол 54 мянгыг оруулж ирсэн. 4 мянгыг нь бол 11 сар гаргаад нөхөж авсан ийм байдалтай байгаа. Дутагдал бол тэгж их байгаагүй. Одоо бол бид нар нөөц бүрдүүлэх чиглэлд тодорхой хэмжээний хөнгөлөлттэй зээлийг аж ахуйн нэгжүүддээ гаргаж өгч байж бид энэ нөөцөө бүрдүүлэх ёстой. Мөн бас манай улсын нийт хэрэглээ жилдээ 20-25 хувиар өсөөд байна. Энэ маань уул уурхайн үйлдвэрлэл, биет хэмжээ эрс өсөж байгаатай холбоотой. Ирэх жил гэхэд бид нар үндсэндээ 2026 онд 100 сая тонн нүүрс экспортолно гэж төлөвлөсөн. Энэ бол бас 20 орчим хувийн өсөлтийг бид нарт өгнө. Ойрын 5 жилдээ манай нефтийн бүтээгдэхүүний хэрэглээ 2 дахин өснө.

Тийм учраас бид бол урьдчилж саваа бэлтгэх, мөн нөөцөө бүрдүүлэх, дэд бүтцээ бий болгох энэ чиглэлд бас энэ хуулийг санаачилж оруулж ирж байгаа юм.

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүн тодруулж асууна.

Н.Батсүмбэрэл: Өмнө нь ОХУ-тай нөгөө байгуулахаар авиа бензиний гэрээний асуудал яриад байсан. Тэр ер нь ямар байдалтай явж байгаа вэ. Тэрийг та бүхэн ойрд оруулж ирэх үү. Тэгээд Оросоос гадна БНХАУ-аас нефть импортолж байгаа асуудал байгаа. Энэ ер нь хэмжээ нь ямаршуу байдаг юм бэ.

Р.Сэддорж: Хариулт 5 номер. Дамдинням сайд.

Г.Дамдинням: Авиа бензиний хэлэлцээр бол өнгөрсөн 4 дүгээр сард Улсын Их Хурлаар орж ирээд буцсан. 8 асуудал яригддаг. Энэ хэлэлцээр бол удахгүй Улсын Их Хурлаар бид бүхэн оруулж ирнэ гэж төлөвлөж байна. 8 бэрхшээлтэй асуудал байснаас 7-г нь ОХУ-ын талтай сая Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлалын хүрээнд хэлэлцээр хийж, Монголын талын томьёоллоор шийдвэрлээ гэдэг шийдвэрт хүрсэн байна. Хэлэлцээ идэвхтэй явагдаж байна. Тун удахгүй Улсын Их Хурлаар гэрээ хэлцлийг байгуулах зөвшөөрөл авахаар Улсын Их Хурал руу оруулж ирнэ.

1 асуудал байгаа. Тэр асуудал нь бол зайлшгүй Их Хурлаар орно. Өөрөөр хэлбэл өнөөдрийн байгуулагдсан гэрээ хэлэлцээний хүрээнд байсан хууль, эрх зүйн орчин ирээдүйд өөрчлөгдвөл энэ гэрээ хэлцэлд хамаарахгүй шүү гэсэн утгатай ийм заалтыг ОХУ-ын талаас заавал оруулж өгөөч гэдэг хүсэлт тавьсан. Энэ заалтаас бусад бүх бүх асуудлууд дээр бол бид нар Монгол Улсынхаа байр суурийг томьёолж хийсэн байгаа. Энэ хууль бол орж ирнэ.

2 дугаарт БНХАУ-аас орж ирэх авто бензин болон дизель түлшний хэмжээг бол нэмэгдүүлж байна. Манай хэрэглээгээ нөхөж байгаа учраас. Дизель түлшний хувьд бол бид нар Петрожайна интернэйшнл компаниас 10 мянган тонн, нийтдээ бол 17,8 мянган тонныг авсан байна. АИ-92 бол 5 мянган тонныг авч байгаа. Бид нар

дамжуулан ачих хүчин чадлаа нэмэгдүүлж байна. Урдаас авах бензин бол Евро-5 стандарттай байдаг учраас үнийн зөрүү бол нэлээн гараад байгаа. АИ-92 авто бензин дээр. Мөн бас дизель түлш дээр. Яагаад вэ гэвэл энэ стандарт нь өндөр юм.

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүн нэмж тодруулж асууя.

Н.Батсүмбэрэл: Энэ мэргэжлийн маягийн л асуулт байх. Би сайн мэдэхгүй байна. АИ-92 дотор нөгөө евро, евро биш гээд байгаа шүү дээ. Энэ ялгаа ер нь ингээд байгаад байх юм уу. Энэ ялгааг ер нь цаашдаа арилгах чиглэлийн бодлого байх уу.

Р.Сэддорж: 6 номер хариулт.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. 92 авто бензин дотроо Евро 2, Евро 3, Евро 4, Евро 5 гээд, Евро 6-д БНХАУ-д шилжчихсэн байна. Энэ бол байгаль орчин, экологид үзүүлэх бохирдлын хэмжээ буюу хүхрийн хэмжээгээрээ ялгагддаг байгаа. Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөрөө ялгардаг байгаа.

Евро 5 стандартын бүтээгдэхүүн бол 10 хүртэл PPM хүхэртэй байдаг бол Евро 2 стандартын бүтээгдэхүүн 500 PPM хүртэл хүхэртэй байдаг. Өөрөөр хэлбэл 50 дахин их хүхэртэй.

Хамгийн гол асуудал бол Монгол Улсад Евро 2 стандартын бүтээгдэхүүн түлхүү хэрэглэж байгаа шалтгаан нь бол цэвэр үнэ. Өнөөдөр 705 ам.доллараар бид нар тогтворжуулсан үнээр Евро 2 стандартын бүтээгдэхүүн худалдаж авч байна. Гэтэл ОХУ-ын зах зээл дээр Евро 5 стандартын бүтээгдэхүүн өөрөө 850 ам.доллар хүрчихсэн байна. Өөрөөр хэлбэл 150 орчим ам.долларын үнийн зөрүүтэй байгаа учраас бид нар литр тутамд энэ маань өөрөөр хэлбэл жижиглэнгийн үнэ дээр бол 400 орчим төгрөгийн зөрүү гараад байгаа. Бид бол сонголтыг бий болгож аль алиныг нь импортолж байгаа. Хэрэглэгч сонгоод хэрэглэх боломжтой. Ер нь 2012 оноос хойш үйлдвэрлэсэн автомашин бол Евро 5 стандартын бүтээгдэхүүнийг хэрэглэх зориулалттай үйлдвэрлэгдсэн байдаг.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд.

Л.Соронзонболд: Агуулгын хувьд бол энэ төслийг дэмжиж байна. Зүгээр гол асуудал нь Монголбанктай энэ асуудлаа хэр сайн ярилцсан бэ. Яагаад гэхээр Төв банкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1-д заасан Төв банканд хийж болохгүй, хориглосон зүйл, заалтуудыг бол энэ хуулийн хүрээнд нээж өгөх гэж байна. Өөрөөр хэлбэл тодорхой компанийн үнэт цаас худалдаж авах, дүрмийн санг худалдаж авах, баталгаа гаргах гэх мэтчилний ийм олон үйлдлүүдийг хийх гэж байна. Тийм учраас эдгээр үйлдэл дээр бол бас тодорхой мөнгөн дүнгийн асуудал ерөөсөө тусгагдаагүй байна. Ерөнхий нөөцийн 50 хувь гэдэг утгаар л юм тавигдсан болохоос биш Монголбанк энэхүү хуулийн хүрээнд хийх гээд байгаа энэ 5 жилийн хугацаанд хэдий хэмжээний алдагдал хүлээх юм. Хэдэн төгрөгийн эх үүсвэр гаргах гээд байгаа юм гэдэг асуудлууд дээр тодорхой судалж, ярьсан зүйлс байна уу. Энэ зүйлс нэлээн тодорхой байх нь зөв байх гэж бодож байна. Тэгээд энэ асуултад эхлээд хариулт авчихъя.

Р.Сэддорж: 5 номер. Дараа нь Монголбанк хариулна.

Г.Дамдинням: Соронзонболд гишүүн бас банк санхүүгийн хүн учраас яг л зөвл а асууж байна даа.

1 дүгээрт бол Монголбанк хүлээх алдагдал байхгүй. Энэ хууль бол анх удаа орж ирж байгаа хууль биш. Ковидын үед 2023 онд 1 тонн тутмын үнэ АИ-92 бензин дээр огцом өсөж, хомсдол үүсэх ийм нөхцөл байдалд бид нар бас орж байсан. Ер нь бол байнга л орж байдаг. Тэгээд энэ үед бол энэ хуулийг 1 удаагийн үйлчлэлтэй хууль болгож батлаад, 3 сарынхаа хэрэглээний төв шатахууныг ОХУ-аас шууд худалдаж авч байсан ийм тохиолдол бол бий. Бид бас энэ боломжийг ашиглаж, дахиж энэ хуулийг хэрэглэе гэдэг ийм зохицуулалт оруулж ирж байна. Стратегийн бараа, бүтээгдэхүүний нөхцөл байдал бас тааварлашгүй байгаа учраас энэ хууль зайлшгүй шаардлагатай байгаа.

Монголбанктai хамтарсан. Монголбанк, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, манай яам хамтарсан ажлын хэсгээс энэ хууль боловсруулагдаж орж ирсэн. Нийт 1 сарын хэрэглээний шатахууны нөөц, хадгалах сав барихад бол 500 тэрбум төгрөгийн эх үүсвэр гарна гэж. 200 мянган тонныг хадгалах саванд.

2 дугаарт бол энийг 1 сарын хэрэглээний шатахууныг худалдан авахад шаардлагатай эх үүсвэр нь бол 560 тэрбум. Ингээд 1 их наяд орчим төгрөгийн эх үүсвэр, зээлийн эх үүсвэр шаардлагатай байгаа. Монголбанк бол энэ дээр алдагдал хүлээхгүй. Монголбанкны төлөөлж ирсэн ажлын хэсгийн 9 дүгээр микрофоныг бас өгөхийг хүсье.

Р.Сэддорж: 9 дүгээр микрофон.

О.Одгэрэл: Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын Санхүүгийн зэх зах зээлийн хэлтсийн ахлах эдийн засагч Одгэрэл байна. Энэ хуулийн төсөл дээр болохоор Монголбанканд репо арилжааны нөхцөлөөр банканд зээл олгох боломжийг нь бол нээж өгч байгаа. Энэ нь болохоор Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа хүүгийн нэгдсэн бодлоготой нийцтэй байгаа. Энэ нь болохоор жишээлбэл тухайн үед бодлогын хүү яаж өөрчлөгдсөн байна. Мөн репо арилжааны нөхцөл нь яаж өөрчлөгдсөн байна. Түүнтэй нийцтэйгээр зах зээлийн нөхцөлөөр банканд нь зээлийн санхүүжилтийг олгох боломжтой болно гэсэн үг. Репо санхүүжилтийнхээ хэмжээг нь болохоор Мөнгөний бодлогын хороо хуралдаад, улирал тутам хуралдаад, тухайн улиралд олгох хэмжээ болон тухайн жилд ч юм уу олгох хэмжээг нь бол батална гэсэн үг. Тэгэхээр урьдчилаад бол ямар хэмжээгээр улиралд нь гаргах шаардлагатай, арилжаагаа зарлах шаардлагатай байгааг нь холбогдох яамдаас нь мэдээллийг нь авч байгаад Мөнгөний бодлогын хорооны хурлаар хэмжээг нь батална гэсэн үг.

Тэгэхээр энэ бол Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа хүүгийн нэгдсэн бодлоготой бол нийцтэй гэсэн үг. Тэгээд төслийн 8.3 дээр болохоор Төв банкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 5, 7 дахь заалт хамаарахгүй гэж тусгаж өгсөн байгаа. Ингэснээрээ аливаа салбар нэгжийг дэмжихгүй, дэмжихийг хориглосон заалтыг нь бол тусгаж өгсөн, зохицуулалтыг нь тусгаж өгсөн гэсэн үг. Энэ хуулийн төсөл дээр.

Р.Сэддорж: Соронзонболд гишүүн тодруулж асууя.

Л.Соронзонболд: Тэгэхээр энэ шатахууны нөөц сав барих, эргэлтийн хөрөнгө санхүүжихэд нийтдээ 1 их наяд 60 тэрбум төгрөг ойролцоогоор хэрэгтэй юм байна

гэж эхний ээлжид харж байна. Тэгэхээр яг энэ хэмжээгээр Засгийн газар дээр бол ямар нэгэн өр үүсэхгүй юм байна гэж ойлголоо. Өөрөөр хэлбэл яг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг дэмжих чиглэлд нь үйл ажиллагаа явуулна гэсэн заалт байна гэж. Энийг тодруулаад асуучихъя.

Р.Сэддорж: 5 номер. Дамдинням сайд.

Г.Дамдинням: Тийм ээ, Соронзонболд гишүүн ээ. Засгийн газар болон Монголбанканд ямар нэгэн өр үүсэхгүй. Цэвэр аж ахуйн нэгжүүд дээр арилжааных нь зээлийн хүүгээрээ өр үүсээд, тэгээд төлөөд ингээд явна.

Р.Сэддорж: Заяабал гишүүн алга байна. Монголбанк, Уул уурхайн яамнаас асууя. Газрын тосныхон байгаа.

Энэ одоогийн шатахууны хомсдол ер нь ямархуу шийдэж байна вэ. Одоо ингээд хөдөө, орон нутгаас явж байгаа мэдээллээс харахад бол ер нь тийм сайн хангагдахгүй байна гээд байна. Тэгээд энэ дээр тайлбарлаач. Яг нарийн тодорхой, аймаг аймгаар нь ч юм уу, бүс бүсээр нь юм уу. Тайлбарлаач.

2 дугаарт нь энэ хууль батлагдвал үр дүн нь хэдэн оны, хэдий үед үр дүн нь гарч эхлэх юм. 6 номер.

Ч.Хишигдалай: Монгол Улс шатахууныхаа хэрэгцээний 85 хувийг төмөр замаар, үлдсэн 15 хувийг Цагаан нуур, Эрээнцав зэрэг боомтуудаар хангадаг байсан. Боршоо. Гэтэл сүүлийн үед ОХУ-ын дотоодын хомсдолтой холбоотойгоор тавьсан хоригтой холбоотой трейдэр болон жижиг үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн экспортыг хязгаарласан. Үүнтэй холбоо баруун аймгийн нутгаар автомашинаар импорт хийгдэхгүй байгаа. Бүх зохицуулалтыг төвийн бүс буюу Улаанбаатар, Эрдэнэт, Сайншанд төмөр замын зангилаа бүсүүдээс хийгдэж байна. Эрээн цав. Үүнтэй холбоотой бас баруун аймгуудад жишээ нь шатахууны хүргэлт саатал учрах, хомсдол үүсэх ийм нөхцөл байдал үүсэж байна. Бид баруун аймгаа бүс нутгаар хил залгаа газруудаас бүтээгдэхүүн импортолж авахад асар өндөр үнэтэй байна. Бид төвийн бүсээр 750 ам.доллараар жишээ нь дундаж бүтээгдэхүүнийг оруулж ирж байхад баруун аймагт 1100 ам.доллараар дизель түлшийг жишээ нь оруулж ирж байгаа. Тэгэхээр аль болох зохицуулалтыг хийгээд, шуурхай ажиллаж байна. Хамгийн сүүлд авсан, өчигдөр гаргасан бидний судалгаагаар Монгол Улсад 40 орчим суманд 92 авто бензин хязгаарлалттай болгож байна. Бид энийг тодорхой хэмжээнд сайжруулах үүргийг өнөөдөр бас үнийн зөвлөлийн хурлыг хуралдуулж, бүх аж ахуйн нэгжүүдийг байлцуулан уг асуудлыг хэзээ богино хугацаанд шийдэх вэ гэдэг асуудлыг ярилцсан. Ойрын 7 хоногт бол шийдээд явна. Тэгэхдээ 1 асуудал байдаг. 1 газар бүтээгдэхүүн хүргэгдэж байхад нөгөө газар дуусаж байдаг. Энэ үйл ажиллагаа бол тасралтгүй циклээрээ явах ёстой. Тэгээд аль болох боломжоороо хүчээ дайчлан ажиллаж байгаа гэдгийг та бүхэнд танилцуулъя.

Р.Сэддорж: Дараагийн асуултад хэн хариулах вэ. Энэ хуулийн хэрэгжилт, үр дүн. 6 номер.

Ч.Хишигдалай: Хууль үйлчилж эхэлснээс хойш үр дүн бол хамгийн богино хугацаанд гаргахыг зорьж байна. Хамгийн түрүүнд гарах үр дүн бол эргэлтийн хөрөнгийн зээл олгох асуудал. Аж ахуйн нэгжүүд боломжтой нийлүүлэгчдээс боломж бүрдсэн тохиолдолд аль болохоор нөөцийн хэмжээг доод тал нь 30 хоногт,

богино хугацаанд нөхөж бүрдүүлэх боломжийг үүсгэхийн тулд энэ хуулийн баталж байгаа. Дараагийн арга хэмжээ бол аж ахуйн нэгжүүдэд бүтээгдэхүүн хадгалах савыг барих зээлийг олгох байгаа. Энэ бол ойролцоогоор 2 жил үргэлжилнэ гэсэн тооцоотой байгаа. 2 жилийн дараанаас бид ямар нэгэн байдлаар юу гэдэг юм. Та нар 1 сарын нөөц хадгалах бүрэн хэмжээний агуулахтай, зээл өгснийхөө хариуд аж ахуйн нэгжүүдийг үүрэгжүүлж, хариуцлага тооцож явах боломж бүрдэнэ.

Р.Сэддорж: Та шатахууны хангалт хамгийн сайн байгаа 3 аймгийг, хамгийн муу хүрэлцэхгүй байгаа 3 аймгийг хэлээдэх дээ. 6 номер.

Ч.Хишигдалай: Яг өнөөдрийн нөхцөл байдлаар хамгийн сайн хангалттай байгаа аймаг бол зүүн 3 аймаг байна. Хангамж тааруу аймаг бол Дундговь аймаг байна. Баянхонгор аймаг байна. Өвөрхангай аймгууд байна. Улаанбаатар хотоос бол түгээлтүүд хийгдэж байгаа. Аймаг хоорондын төвийн зам дамждаг учраас тухайн аймгуудад байгаа ШТС-уудын ачаалал их байгаа. Үүнтэй холбоотой бүтээгдэхүүний эргэлт хурдассан асуудал байгаа. Түгээлтийг аль болохоор зохицуулалт хийж байна. Ойрын хугацаанд бол жигдрүүлэхээр ажиллаж байна.

Р.Сэддорж: Таны ярьж байгаа юу ч бас жоохон зөрүүтэй байна даа. Тэгээд Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд шатахууны хангалтын талаар бодитой мэдээллийг аймаг, сумаар нь өгөөдхөөрэй. Тэгэхгүй бол наадах чинь гишүүд ийм зөрүүтэй мэдээлэлтэй байвал болохгүй.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Саналын томьёолол. Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 65 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн танилцуулна. Хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

17.47 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Дулааны цахилгаан станцуудын хаягдал үнстэй холбоотой асуудлаарх мэдээллийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүний санаачилгаар 2025 оны 6 дугаар сарын 4-ний өдөр Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо болон Инновац, цахим бодлогын байнгын хороо хамтран хаягдал үндэсний

ашиглалт, байгаль орчны нөлөөллийн талаар салбар дундын асуудал сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд дээрх Монгол Улсын Их Хурлын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Байнгын хороод татан буугдаж, эрхлэх асуудлын харьяалал, чиг үүрэг нь Эдийн засгийн байнгын хороонд шилжсэн тул тус хэлэлцүүлгийн үр дүнг Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх шаардлагатай болсон.

Иймээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн зүйлийг үндэслэн энэ мэдээллийг Байнгын хороогоор хэлэлцэж байна.

Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүнийг мэдээллээ танилцуулахыг урьж байна. Цэнгүүн гишүүний микрофоныг нээе.

С.Цэнгүүн: Сүүлд нь санал хураалтаар үндсэндээ тогтоол гаргахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт байгаа. Тэгээд танилцуулгаа ерөнхийдөө бид маш хурдтай хийчихье.

Өмнө нь бол Инновацийн байнгын хороо, Аж үйлдвэржилтийн байнгын хорооны хамтарсан хэлэлцүүлгээр бас Цахилгаан станц-2, 3, 4-ийн төлөөллүүд, тэгээд ерөнхийдөө энэ цахилгаан станцууд дээр үнсний хэрэглээг яаж нэмэгдүүлэх талаар бол олон талын судлаач нар хамрагдсан ерөнхийдөө 60 орчим хүний хэлэлцүүлэг хийгдээд тухайн Байнгын хороод дээр гишүүд нь саналаа өгөөд, дэмжээд явчихсан.

Тогтоолоо батлах гэсэн чинь Байнгын хороо татан буугдаад, тэгээд Эдийн засгийн байнгын хороо руу шилжээд орчихсон ийм асуудал байгаа. Тэгээд гишүүддээ болохоороо энэ цахилгаан станцуудын үнстэй зайлуулахтай холбоотой 1 цахилгаан станц дээр л гэхэд 200-300 сая төгрөгийн зардал гарч байгаа. ТЭЦ-4 дээр бол жишээ нь 2 тэрбум төгрөгийн зардлыг бид нар үнс зайлуулахтай холбоотой гаргадаг. ТЭЦ-3-ын тухайд бол үнсэн усан сан гэж бид нар нэрлэдэг. Тэр газар маань дүүрээд, одоо нийслэлээс ахиад шинэ газар аваад, дахиад нөгөө хуучин үнсэн сангаа автомашинаар тээвэрлээд, шинэ авч байгаа газар луугаа зөөх гэх мэт ийм хүндрэлтэй асуудлууд үүсээд байгаа.

Тэгээд энэ маань байгаль орчин, хүний эрүүл мэнд энэ зүйлүүд дээр бол асар муугаар нөлөөлдөг. Бусад улсуудад бол нийт нүүрсэн станцын гарч байгаа хэрэглээний 40 орчим хувийн үнсээ ашигладаг бол манайд 5 орчим хувийг нь ашиглаж байгаа. Үндсэндээ бол үүнтэй холбоотой үнсээ юунд ашиглаж болох вэ гэхээр бид бүхэн замын чигжээс, тэгээд барилгын материал үйлдвэрлэлд энэ үнсийг ашиглах боломжтой байдаг. Тэгээд хууль тогтоомжууд нь байдаг ч гэсэн хэрэгжилт их багатай байгаа учраас энийг Засгийн газраас нөгөө хэрэгжилтийн уялдаа холбоог нь дэмжиж өгөөч гэдэг тогтоол батлуулахаар бол танилцуулж байгаа. Та бүхэнд.

Тэгээд санал хураалтаа гаргаад, тогтоолын төсөл нь байгаа. Хувийн хэвшил. Төр бол ямар ч оролцоотой биш.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Эрчим хүчний яам Лувсанцэрэн Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Мөнхөө Амгалан дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал, Минжинхүү Дулааны 2 дугаар цахилгаан станц ТӨК-ийн гүйцэтгэх захирал, Төмөрхуяг Дулааны 4 дүгээр цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал, Амартүвшин Дулааны 3 дугаар цахилгаан станц ТӨХК-ийн Техникийн бодлогын хэлтсийн дарга, Ангараг Амгалан

дулааны станц ТӨХК-ийн Үйлдвэрлэлийн бодлого, шуурхай албаны хэлтсийн дарга, Бямбадорж Дулааны 5 дугаар цахилгаан станц ОНӨААТҮГ-ын дарга, Болдбаатар Дулааны 4 дүгээр цахилгаан станц ТӨХК-ийн ерөнхий инженер, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яа. Батзориг Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын Барилгын материал үйлдвэрлэлийн хэлтсийн дарга, Энхтүвшин Барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн ахлах шинжээч, Хувийн хэвшил, иргэдийн төлөөллөөс Сүнжидмаа Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн профессор, Монгол Улсын зөвлөх инженер, Баяржавхлан ШУТИС-ийн багш, Эрдэмбилэг Монцемент бюлдинг материалс компанийн үйлдвэрийн менежер, Оюунгэрэл Ховд Эко цемент үйлдвэрийн технологич, инженер, Мөнхбат Монгол цемент үйлдвэрлэгчдийн ассоциацийн гүйцэтгэх захирал, Галсанбуян Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны эксперт.

Гишүүний мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Алга байна. Танилцуулгатай холбогдолтой асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Батсүмбэрэл гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл.

Н.Батсүмбэрэл: Сая хурал эхлэхэд энэ материал тараагдлаа л даа. Тэгээд 20 нүүр бүхий хавсралттай. Тэр хавсралтад хэлэлцүүлгийн тэмдэглэл байгаад байгаа. Тэгээд энийг нэлээн үзмээр юм байна. Ямар ч байсан гүйлгэж ямар ч байсан үзэж байж, энийг бас яримаар байгаа юм. Тэгээд өнөөдөр энд байгаа хүмүүс чинь уулзчихаад, дараагийн хурал дээр байх юм уу, байхгүй юм уу энэ чинь. Жишээ нь өмнөх Байнгын хороонд байсан бөгөөд энэ хэлэлцүүлэг дээр байсан хүмүүс бол мэдээлэлтэй байгаа байх. Жишээ нь өнөөдөр яг материал авс авсан хүмүүст мэдээлэл байхгүй байдаг. Сэдэв маань өөрөө маш чухал сэдэв байгаад байдаг. Тэгээд энийг ер нь нэлээн нухацтай үзэх нь зүгээр юм болов уу гэж бодоод байна.

Тэгээд тэр зарчмыг нь сайн ойлгосонгүй л дээ. Тэгээд энийг сонссон гэж үзээд, тэгээд шууд тогтоол гаргах гээд байгаа юм байна гэж ойлголоо. Зөв ойлгосон уу, буруу ойлгосон уу.

Гэтэл энэ ажлын хэсэг гээд орж ирж байгаа хүмүүс маань тодорхой асуултад хариулах бодолтой ирсэн байх гэж бодоод байгаа. Бэлтгэлтэй. Гэтэл энэ 20 нүүр хуудсыг лав л би уншиж амжаагүй байна. Сая өмнө нь 2 ч хууль гэж явсаар байгаад. Энийг уншаагүй байж байж юм асуухаар чинь зохимжгүй байгаад байна. Угтаа бол энэ сэдэв өөрөө чухал учраас энийг судлах нь зүйтэй л гэсэн ийм саналтай байгаа. Тэгээд тэр тогтоол батлах бол зарчмын хувьд бол зөв байх. Тэгээд тогтоолоо хэлэлцэх үедээ дахиад энийг тодотгоод уншчихаад асуувал яасан юм бэ. Ингэхгүй бол бас хуумгай юм болох гээд байна. Тэгээд энэ чинь бас маш олон талын л оролцогч оролцсон юм байна. ТЭЦ-ийн хүмүүс оролцсон юм байна. Тэр компани, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон юм байна. Шийдвэр гаргах түвшний яамны хүмүүс оролцсон юм байна. Би ийм саналтай байгаад байна. Байнгын хорооны дарга аа, энийгээ нэгмөсөн тэр тогтоолтой хамт асуулт, хариулт явуулах нь зөв байх.

Р.Сэддорж: Ирэх 7 хоногт тогтоолын төсөл хэлэлцэхэд гишүүд асуулт асууж, үг хэлж болох юм байна. Ирэх 7 хоногт.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Цэнгүүн гишүүн горимын санал.

С.Цэнгүүн: Тэгэхээр цахилгаан станцуудын үнс ашиглалттай холбоотой асуудлыг бол Аж үйлдвэржилтийн байнгын хороо, Инновацын байнгын хороо дээр

бол хамтарсан хуралдаанаар сонссон байгаа. Тэгэхээр Эдийн засгийн байнгын хороо дээр дахиж ажлын хэсгийн бүрэлдэхүүнээрээ сонсоод, тэгээд сонсголынхоо үр дүнд болохоороо бид бүхэн тогтоол батлуулахаар зорьж байгаа. Тийм учраас ирэх 7 хоногт дараагийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар тогтоол батлуулах горимын санал гаргаж байна. Энэ саналыг дэмжиж өгөөч гэж хүсье.

Р.Сэддорж: Гишүүд мэдээлэлтэй холбогдуулж тогтоол гаргахыг дэмжих санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье.

Цэнгүүн гишүүний гаргасан горимын саналаар мэдээлэлтэй холбогдуулж тогтоолын төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хаягдал хүнсний ашиглалт, байгаль орчны нөлөөллийн талаар салбар дундын асуудал сэдэвт хэлэлцүүлгийн талаарх хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж байна. Хуралдаан үүгээр өндөрлөснийг мэдэгдье. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын хэсэгт баярлалаа.

17.57 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ